



**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

2012 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Г “Монголын төмөр зам” ТӨХК-ийн үнэт цаасны Ү  
бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйл, Хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын 7.1 дэх заалт, Төрийн өмчийн хорооны 2011 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 68 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гаргасан энгийн хувьцааг нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 207,051,000 /хоёр зуун долоон сая тавин нэгэн мянга/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 207,277,000 /хоёр зуун долоон сая хоёр зуун далан долоон мянга/ ширхэг энгийн хувьцаа байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТТХТ” ХХК/Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Монголын төмөр зам” ТӨХК/Б.Батзаяа/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-т тус тус үүрэг даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН